



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/17/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2022 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: Erdenechimegg@audit.gov.mn

Аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: davaanyamb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	2
2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл	3-8
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	3
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн өмчийн өөрчлөлийн тайлан	4
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	4-5
2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	5-6
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	7
3. Аудитын тайлан	8
3.1 Ерөнхий зүйл	8
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	8
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	9
3.4 Материаллаг байдал.....	9
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	9-12
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12-14
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	16
4. Аудитын илрүүлэлт.....	17
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	18



ХАТГАЛ ТОСГОНЫ ЗАХИРАГЧ А.БАТТУШИГ
ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хатгал тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хатгал тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Хатгал тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагч төсөв, санхүүгийн хувьд Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан чиг үүргийн төсвийг төлөвлөх, төсвийн шууд захирагчид хуваарилах, хяналт тавих, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх, үүрэг хэрэгжүүлэхээс гадна Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дугаар зүйлийн 31.1 дэх зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлдэг.

Хатгал тосгоны захирагчийн аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний 140 зорилт, 212 арга хэмжээний хэрэгжилт 87.2 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА , ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

<i>Мян.төг</i>			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	432,226.4	740,113.4
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	74,920.1	165,581.4
33	АВЛАГА	2,686.9	41,290.8
35	БАРАА МАТЕРИАЛ	354,619.4	533,241.2
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,483,811.6	4,932,543.3
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,483,811.6	4,932,543.3
39200	Биет хөрөнгө	4,265,449.8	4,693,429.4
39300	Биет бус хөрөнгө	218,361.8	239,113.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,916,038.0	5,672,656.7
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	1,120.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	1,120.1
41300	Өглөг	0.0	1,120.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,916,038.0	5,671,536.5
51	Засгийн газрын хувь оролцоо	4,916,038.0	5,671,536.5
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,768,544.6	1,768,544.6
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0.0	380,890.9
51200	Хуримтлагдсан үр дүн	2,262,092.6	2,527,591.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	885,400.8	994,509.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,916,038.0	5,672,656.7

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

<i>Мян.төг</i>			
Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,610,350.6	3,860,864.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	141,274.6	305,268.3
110	Орлогын албан татвар	46,997.0	66,089.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	46,997.0	66,089.4
113	Хөрөнгийн албан татвар	1,680.0	11,894.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	92,597.6	227,284.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,305,913.7	604,732.9
120	Нийтлэг татварын бус орлого	1,305,913.7	604,732.9
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,163,162.3	2,950,863.1
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,429,143.8	3,586,023.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,429,143.8	3,586,023.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,334,593.3	3,427,080.5
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,531,555.9	2,035,903.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	203,138.6	266,104.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,792.8	113,833.3
2104	Хангамж, бараа материалын зардал	64,420.8	124,795.4
2105	Нормативт зардал	55,129.7	323,150.8
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,875.8	49,477.4
2107	Томилот, зочны зардал	3,842.9	2,221.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	95,628.8	83,141.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	294,208.1	428,453.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	94,550.5	158,943.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,181,206.8	274,840.8
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	605.0	27,640.9
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,180,601.8	247,199.9

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Мян.төг

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,735,436.2	0.0	3,735,436.2
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,735,436.2	0.0	3,735,436.2
9	Тайлант үеийн үр дүн	1,180,601.8	0.0	1,180,601.8
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,916,038.0	0.0	4,916,038.0
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,916,038.0	0.0	4,916,038.0
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	516,576.3	0.0	516,576.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,432,614.3	0.0	5,432,614.3
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-7,020.0	0.0	-7,020.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-1,257.6	0.0	-1,257.6
19	Тайлант үеийн үр дүн	247,199.8	0.0	247,199.8
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,671,536.5	0.0	5,671,536.5

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мян.төг

Код:	Тайлангийн үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,373,980.4	3,252,149.4
11	ТАТВАРЫН ОРЛОГО	141,274.6	305,268.3
110	Орлогын албан татвар	46,997.0	66,089.4
1100	Хувь хүний орлогын албан татвар	46,997.0	66,089.4
113	Хөрөнгийн албан татвар	1,680.0	11,894.1
118	Бусад татвар, төлбөр, хураамж	92,597.6	227,284.8
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	18,727.9	14,134.2
1181	Газрын төлбөр	289.7	4,216.4
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	73,579.9	208,934.1
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	69,543.4	32,799.3
120	Нийтлэг татварын бус орлого	69,543.4	32,799.3
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,163,162.3	2,914,081.8
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,255,610.2	2,987,230.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,255,610.2	2,987,230.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,161,059.8	2,828,287.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,562,725.5	2,050,400.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	205,526.6	272,788.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	91,926.1	119,990.2
2104	Хангамж, бараа материалын зардал	94,591.3	113,395.0
2105	Норматив зардал	75,011.8	134,657.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	42,551.0	27,664.4
2107	Томилолт, зочны зардал	3,842.9	2,221.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,267.2	72,104.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,617.4	35,065.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	94,550.5	158,943.0
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	118,370.1	264,919.4
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	89,744.0	174,258.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	89,744.0	174,258.2
2200	Дотоод эх үүсвэрээр	89,744.0	174,258.2



VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-89,744.0	-174,258.2
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	28,626.1	90,661.2
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	46,293.9	74,920.1
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	74,920.1	165,581.3

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

					Мян.төг
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,985,699.8	2,886,928.9	98,770.9	96.7
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,858,403.6	2,790,346.9	68,056.7	97.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,783,127.0	2,717,276.6	65,850.4	97.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,972,713.7	1,957,784.2	14,929.5	99.2
210101	Үндсэн цалин	1,353,162.0	1,336,014.1	17,147.9	98.7
210102	Нэмэгдэл	461,245.8	459,785.9	1,459.9	99.7
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,056.0	7,056.0	0.0	100.0
210104	Урамшуулал	109,382.1	113,060.4	-3,678.3	103.4
210105	Гэрээт ажлын хөлс	41,867.8	41,867.8	0.0	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	265,982.3	259,387.8	6,594.5	97.5
210201	Тэтгэврийн даатгал	187,073.7	180,479.2	6,594.5	96.5
210202	Тэтгэмжийн даатгал	19,727.1	19,727.1	0.0	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	15,781.6	15,781.6	0.0	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	3,945.6	3,945.6	0.0	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	39,454.3	39,454.3	0.0	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	129,777.4	126,594.0	3,183.4	97.5
210301	Гэрэл, цахилгаан	24,260.0	21,409.5	2,850.5	88.3
210302	Түлш, халаалт	97,494.2	96,966.7	527.5	99.5
210303	Цэвэр, бохир ус	8,023.2	8,217.8	-194.6	102.4
2104	Хангамж, бараа материалын зардал	91,506.5	91,300.5	206.0	99.8
210401	Бичиг хэрэг	6,353.7	6,353.7	0.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	37,275.0	37,275.0	0.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,655.8	8,449.8	206.0	97.6
210404	Ном, хэвлэл	639.7	639.7	0.0	100.0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	19,564.6	19,564.6	0.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,017.7	19,017.7	0.0	100.0
2105	Норматив зардал	136,208.7	110,709.6	25,499.1	81.3
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	37,293.3	37,293.3	0.0	100.0
210502	Хоол, хүнс	93,734.1	68,235.0	25,499.1	72.8
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,181.3	5,181.3	0.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	108,366.1	102,166.1	6,200.0	94.3
210601	Багаж, техник, хэрэгсэл	22,509.0	22,509.0	0.0	100.0
210602	Тавилга	63,300.0	59,100.0	4,200.0	93.4
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,083.0	2,083.0	0.0	100.0
210604	Урсгал засвар	20,474.1	18,474.1	2,000.0	90.2
2107	Томиллолт, зочны зардал	2,868.2	1,933.6	934.6	67.4
210702	Дотоод албан томилолт	2,868.2	1,933.6	934.6	67.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	41,203.6	38,115.2	3,088.4	92.5

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,608.8	34,646.4	2,962.4	92.1
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,235.0	2,120.0	115.0	94.9
210803	Даатгалын үйлчилгээ	295.0	295.0	0.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	76.4	76.4	0.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	44.0	33.0	11.0	75.0
210807	Газрын төлбөр	44.4	44.4	0.0	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	900.0	900.0	0.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	34,500.5	29,285.6	5,214.9	84.9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,329.0	15,114.1	5,214.9	74.3
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,171.5	14,171.5	0.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	75,276.6	73,070.3	2,206.3	97.1
2132	Бусад урсгал шилжүүлэг	75,276.6	73,070.3	2,206.3	97.1
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	45,314.8	43,108.5	2,206.3	95.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,861.8	28,861.8	0.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,100.0	1,100.0	0.0	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	127,296.2	96,582.0	30,714.2	75.9
223001	Бусад хөрөнгө	127,296.2	96,582.0	30,714.2	75.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,985,699.8	2,913,953.4	71,746.4	97.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,302,636.0	2,260,014.9	42,621.1	98.1
310003	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	2,240,389.5	2,197,768.4	42,621.1	98.1
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	62,246.5	62,246.5	0.0	100.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	582,860.3	612,987.7	-30,127.4	105.2
320001	Орон нутгийн төсвөөс	582,860.3	612,987.7	-30,127.4	105.2
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	41,708.7	40,950.8	757.9	98.2
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	41,708.7	40,950.8	757.9	98.2
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	58,494.8	0.0	58,494.8	0.0
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	58,494.8	0.0	58,494.8	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	50.3	-50.3	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	27,074.3	-27,074.3	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	1,097.00	1,279.00	-182.0	116.6
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	5.00	5.00	0.0	100.0
610001	Төсвийн байгууллага	5.00	5.00	0.0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	167.00	167.00	0.0	100.0
620001	Удирдах ажилтан	8.00	8.00	0.0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	89.00	93.00	-4.0	104.5
620003	Үйлчлэх ажилтан	67.00	63.00	4.0	94.0
620004	Гэрээт ажилтан	3.00	3.00	0.0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Мян.төг

Код	Үзүүлэлт	ТЗ цэвэр дүн
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	194,670.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	194,670.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	163,670.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	75,092.06
210101	Үндсэн цалин	24,141.69
210102	Нэмэгдэл	40,123.50
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,089.87
210104	Урамшуулал	7,737.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	7,771.14
210201	Тэтгэврийн даатгал	7,771.14
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	150.00
210303	Цэвэр, бохир ус	150.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,803.06
210401	Бичиг хэрэг	1,845.85
210402	Тээвэр, шатахуун	5,312.93
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	110.00
210404	Ном, хэвлэл	3,645.90
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,888.38
2105	Норматив зардал	23,947.42
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	17,202.70
210502	Хоол, хүнс	6,744.72
2107	Томилолт, зочны зардал	288.00
210702	Дотоод албан томилолт	288.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,838.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	30,409.68
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,428.70
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,780.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,985.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,795.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	31,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	196,136.71
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	196,136.71
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	7,916.30
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,400.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	43,393.11
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	9,138.60
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого	128,288.70
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	1,466.46
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,466.46

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн төвлөрүүлэн захирагч Д.Амартүвшин танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн төсвийн шууд захирагчдын санхүүгийн тайланд гарсан зөрчил, дотоод хяналт, төсвийн төлөвлөлт, орлого бүрдүүлэлттэй холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Давааням гүйцэтгэж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Б.Тэгшдэлгэр хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн

Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 1/214 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хатгал тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагч нь стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжийн хэрэгжилт, хөтөлбөр, төслийн биелэлт зэргийг Засаг даргын дэргэдэх тасаг, алба, албан байгууллага, аж ахуйн нэгжид хэрхэн хэрэгжиж байгааг хянах, шалгах, зохицуулах, чиглэл өгөх, мэдээлэл авах зэрэг эрхтэйгээс гадна дээрх байгууллагаар дамжуулан мэдээллийг цуглуулж хяналт шинжилгээ хийх дүгнэлт гаргах үүрэгтэй ажилладаг орон нутгийн төсвийн захирагч юм.

Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант хугацаанд “Олон нийтийн оролцоонд тулгуурласан, ил тод хариуцлагатай засаглалтай иргэдээ дээдэлсэн төрийн үйлчилгээг эрхэмлэн, сумын хөгжил дэвшлийг оновчтой бодлогоор хангана” гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагч нь санхүүгийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан “Хөвсгөл аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа хууль тогтоомжуудад өөрчлөлт орсон хэдий ч Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг шинэчлэгдсэн хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөлт оруулаагүй байна.

ТТЗ-ийн хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Сумын Засаг даргын дэргэдэх орон тооны бус дотоод хяналтын нэгж нь тайлант онд дараах чиглэлээр хяналтыг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт
- Орон нутгийн орлого бүрдүүлэлт



- Эд хөрөнгийн ашиглалт хамгаалалт
- Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл
- ОНХС-ийн төлөвлөгөө гүйцэтгэл
- Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын зарцуулалт
- Нэрлэсэн жил хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Хяналтаар илэрсэн алдаа зөрчилд нийт 5 зөвлөмжийг холбогдох байгууллагуудад өгсөн бөгөөд хэрэгжилтийг тооцоогүй байна. Цаашид илэрсэн зөрчилд хугацаатай зөвлөмжийг өгч хэрэгжилтийг тооцож ажиллах нь зүйтэй байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

Хатгал тосгоны ТТЗ-ийн харьяа байгууллагуудад ТЕЗ-ийн дэргэдэх Санхүүгийн хяналт аудитын албанаас хяналт шалгалтыг хийсэн бөгөөд илэрсэн зөрчлийг арилгаж биелэлтийг хангаж ажилласан байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-д нийцүүлэн нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна гэж үзлээ.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн болох 2,982.7 сая төгрөгөөс 2 хувиар буюу 59.6 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 47.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 74.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 165.6 сая төгрөг болж 90.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Төрийн сангийн харилцах	70.7	165.3	90.7
Арилжааны банк	4.2	0.3	-3.8
Дүн	74.9	165.6	90.7
Үүнээс: Байгууллагаар харуулбал			
Орон нутгийн ерөнхий орлого	70.7	136.8	66.1
Орон нутгийн хөгжлийн сан	0.05	27.1	27.1
Хатгал цахир	4.2	0.3	-3.8
Хүүхдийн цэцэрлэг	0.005		-0.005
Эрүүл мэндийн төв		1.5	1.5

Эх сурвалж: Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан



Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 165.3 сая төгрөг нь төрийн сангийн харилцах дансанд, 0.3 сая төгрөг нь арилжааны банканд байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нэмэгдсэн нь орон нутгийн орлого давж биелснээс дансны үлдэгдэл 136.8 сая төгрөг болж нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд харьяа байгууллагуудад олгосон 711.5 сая төгрөгийн санхүүжилтийн гүйлгээг орлого, зарлага талд нь устгаж цэвэр дүнгээр нэгтгэн тайлагнасан байна.

ТТЗ-ийн харьяа Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн дансанд 2021.12.31-ны өдрийн байдлаар 1.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7."Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.5.2 Богино хугацаат хөрөнгө оруулалт

Богино хугацаат хөрөнгө оруулалт дансанд гүйлгээ байхгүй байна.

3.5.3 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 2.7 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 41.3 төгрөг болж 38.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Авлага /сая төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт, бууралт/+, -/
Хүүхдийн цэцэрлэг	1.9	-	-1.9
Соёлын төв	0.3	-	-0.3
Ерөнхий боловсролын сургууль	0.5	-	-0.5
Эрүүл мэндийн төв	-	41.3	41.3
Нийт дүн	2.7	41.3	38.6

Эх сурвалж: Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тус тосгоны Эрүүл мэндийн төвийн төлбөртэй үйлчилгээний авлага 41.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

3.5.4 Урьдчилгаа

Урьдчилж төлсөн төлбөрийн тооцоо байхгүй болно.

3.5.5 Бараа материал

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 354.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 533.2 сая төгрөг болж 178.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засаг даргын Тамгын газар	40.6	64.2	23.6
Соёлын төв	22.5	24.7	2.2
Ерөнхий боловсролын сургууль	221.7	211.6	-10.1
Хүүхдийн цэцэрлэг	69.9	67.4	-2.5
Эрүүл мэндийн төв	-	165.4	165.4
Нийт дүн	354.6	533.2	178.6

Эх сурвалж: Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн шалтгаан нь тайлант онд Хатгал сум дундын эмнэлгийг эрүүл мэндийн төв болгон санхүүгийн тайланг ТТЗ-ийн тайланд нэгтгэсэнтэй холбоотой бараа материалын үлдэгдэл нэмэгдсэн байна.



3.5.6. Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалт дансанд гүйлгээ байхгүй байна.

3.5.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,483.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 4,932.5 сая төгрөг болж 448.7 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт/-
Засаг даргын Тамгын газар	1,838.8	1,860.6	21.8
Соёлын төв	94.7	99.5	4.8
Ерөнхий боловсролын сургууль	1,285.5	1,259.1	-26.4
Хүүхдийн цэцэрлэг	1,264.3	1,240.8	-23.5
Эрүүл мэндийн төв	-	472.5	472.5
Хатгал цахир	0.4	-	-0.4
Нийт дүн	4,483.8	4,932.5	448.7

Эх сурвалж: Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгө нэмэгдсэн шалтгаан нь элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүдийг үнэ тогтоож орлого авсан, Эрүүл мэндийн төвийн 472.5 сая төгрөгийн хөрөнгө санхүүгийн тайланд нэмэгдсэн зэргээс хамаарсан байна.

3.5.8 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 0 төгрөг, эцсийн үлдэгдэл 1.1 төгрөг болж 1.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №7 Нийт төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Байгууллага	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Ерөнхий боловсролын сургууль	0	0.8	0.8
Хүүхдийн цэцэрлэг	0	0.3	0.3
Нийт дүн	0	1.1	1.1

Эх сурвалж: Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өр төлбөр нэмэгдсэн нь хүүхдийн цэцэрлэгийн ажилчидтай холбоотой өглөг, Ерөнхий боловсролын сургуулийн бараа үйлчилгээний зардлын өглөг нэмэгдсэнтэй холбоотой байна.

3.5.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 4,916.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 5,671.5 сая төгрөг болж 755.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Хүснэгт №8 Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,768.5	1,768.5	-
Өмч /Төрийн/ТӨҮГ	-	380.9	380.9
Хуримтлагдсан үр дүн	2,262.1	2,527.6	265.2
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	885.4	994.5	109.1
Нийт дүн	4,916.0	5,671.5	755.5

Эх сурвалж: Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл нэмэгдсэн нь Эрүүл мэндийн төвийн 380.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэгдсэнээс шалтгаалсан байна.

3.5.10 Орлогын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангаар нийт 3,860.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж тайлагнасан байна. Тайлант онд бүрдүүлсэн орлогыг өмнөх онтой харьцуулахад 250.5 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.



Хүснэгт №9 Санхүүгийн үр дүнгийн нийт орлого /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү
Татварын орлого	141.3	305.3	164.0
Татварын бус орлого	1,305.9	604.7	-701.2
Тусламж санхүүжилтийн орлого	2,163.2	2,950.9	787.7
Нийт дүн	3,610.4	3,860.9	250.5

Нийт орлогын дүн нэмэгдсэн шалтгаан нь орон нутгийн орлого давж биелсэн, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, нэмэлт санхүүжилтийн орлого нэмэгдсэн зэрэг нь нөлөөлсөн байна. Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 745.2 сая төгрөгийн орлогын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.5.11 Зардлын данс

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангаар 3,613.6 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Хүснэгт №10: Санхүүгийн үр дүнгийн нийт зардал /сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	зөрүү
Үйл ажиллагааны зардал	2,429.1	3,586.0	1,156.9
Үйл ажиллагааны бус зардал	0.6	27.6	27.0
Нийт дүн	2,489.7	3,613.6	1,183.9

Эх сурвалж: Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Нийт зардлын дүн өссөн нь цалингийн урамшууллын зардлын дүн 504.4 сая төгрөгөөр, эм бэлдмэл, эмнэлгийн хэрэглэлийн зардал 255.0 сая төгрөгөөр, эд хогшил урсгал засварын зардал 42.6 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардал 761.4 сая төгрөгөөр өссөн зэргээс шалтгаалсан байна. Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд харьяа байгууллагуудын 745.2 сая төгрөгийн зарлагын давхардсан гүйлгээг устгаж цэвэр дүнгээр тайлагнасан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны төсвийн төслийг харьяа байгууллагуудын хүрээнд нэгтгэн боловсруулж, дээд шатны төсөв захирагчид хүргүүлээгүй байна. Зөвхөн орон нутгийн төсвөөс санхүүжиж байгаа байгууллагуудын төсвийг нэгтгэж хүргүүлсэн ба боловсрол, эрүүл мэндийн байгууллагууд нь аймгийн Боловсрол соёлын газар, Эрүүл мэндийн газарт хүргүүлсэн байна.

Алаг-Эрдэнэ сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 12 дүгээр тогтоолоор Хатгал тосгоны Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрт зориулан 2,773.4 сая төгрөгийн төсөв баталснаас 2,570.0 сая төгрөгийг урсгал зардалд, 203.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар баталжээ.

Батлагдсан төсвийн 2,153.8 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 60.4 сая төгрөгийг ОНХС-аас, 478.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, орон нутгийн орлогоос, 41,7 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас, давсан орлого дансны үлдэгдлээс 38.7 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант онд Хатгал тосгоны ИТХ-ын 2021 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 15 дугаар тогтоолоор төсөвт 181.7 сая төгрөгийн нэмэх тодотгол хийж төсвийг 2,955.1 сая төгрөгөөр баталсан байна.

Тодотголоор Хүүхдийн цэцэрлэг 46.9 сая төгрөгийн хасах, захирагчийн ажлын алба 121.9 сая төгрөг, ОНХС 1.8 сая төгрөг, ЕБС 104.9 сая төгрөгийг нэмэх тодотгол хийсэн байна. Тодотгол хийсэн шалтгаан нь Захирагчийн ажлын албаны гэрээт ажилчдын цалин, гэрэл цахилгаан, бичиг хэрэг, бараа үйлчилгээний бусад зардал, хог хаягдлын хураамж, тээвэр шатахууны зардал, усны машин худалдан авах зэргээс шалтгаалсан байна.



Аймгийн Засаг даргын захирамжаар Ерөнхий боловсролын сургуулийн төсөвт зохицуулалт хийхдээ тусгай шилжүүлгийн байгууллагын төсвөөс 28.5 сая төгрөг, Соёлын төвд орон нутгийн төсвөөс 2.0 сая төгрөгийг зохицуулалтаар тус тус нэмж хуваарилсан байна. Энэ нь ТТЗ-ийн батлагдсан төсөвт зөрүү үүсэх шалтгаан болсон байна. Төсөвт зохицуулалт хийснээр нийт төсөв 2,985.7 сая төгрөг болсон байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Сумын төсвийн орлого бүрдүүлэлт.

Алаг-Эрдэнэ сумын ИТХ-ын 2021 оны орон нутгийн төсөв батлах тухай 2021 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 12 дугаар тогтоолд зааснаар Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 208.5 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталсан байна. Гүйцэтгэлээр 316.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөө 152.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт №11. Орон нутгийн орлого /сая төгрөг/

Үйл ажиллагааны орлого	17,500.0	6,462.2	-11,037.8	36.9
Хөрөнгийн орлого	25,000.0	29,251.2	4,251.2	117.0
Хөрөнгө борлуулсны орлого	14,500.0	30,157.9	15,657.9	208.0
Шууд бус орлого	150.0	218.1	68.1	145.4
Бууны албан татвар	1,710.0	1,823.0	113.0	106.6
Малд ногдуулах албан татвар	0.0	10,071.1	10,071.1	0.0
Улсын тэмдэгтийн хураамж	6,300.0	7,010.3	710.3	111.3
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	95.2	185.0	89.8	194.3
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	7,486.8	6,938.9	-547.9	92.7
Газрын төлбөр	5,160.0	4,216.4	-943.6	81.7
Ойн нөөц ашигласны төлбөр	120,000.0	207,600.0	87,600.0	173.0
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	200.0	280.0	80.0	140.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	600.0	610.0	10.0	101.7
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	200.0	444.2	244.2	222.1
Торгуулийн орлого	8,500.0	10,575.1	2,075.1	124.4
Бусад орлого	1,100.0	1,110.4	10.4	101.0
Дүн	208,502.0	316,953.9	108,451.9	152.0

Эх сурвалж: Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Орон нутгийн орлогын төлөвлөгөө 108.4 сая төгрөгөөр давж биелэхэд ойн нөөц ашигласны төлбөрийн орлого 87.6 сая төгрөгөөр, хөрөнгө борлуулсны орлого 15.6 сая төгрөгөөр, хөрөнгийн албан татварын орлого 10.2 сая төгрөгөөр тус тус давж биелсэн нь нөлөөлсөн байна.

Орон нутгийн орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл:

Орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл үйл ажиллагааны орлого 11.0 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 0.6 сая төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 0.9 сая төгрөгөөр нийт 12.5 сая төгрөгийн орлого тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1. "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Энэ нь Ковид-19 цар тахлын улмаас жуулчны баазууд хэвийн ажиллаагүйгээс үйл ажиллагааны орлого албан татварын орлого тасарсан, хог хаягдлын хураамжийн орлогын санхүүжилтийг засгийн газраас өмнөх оны гүйцэтгэлээр олгосон, газрын төлбөрийн орлого Алаг-Эрдэнэ сумын ерөнхий орлогын дансанд орсон зэргээс хамаарсан байна.

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд аймагт төвлөрүүлэх орлогыг 196.5 сая төгрөгөөр төлөвлөж 220.8 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 24.3 сая төгрөг буюу 12.3 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт №12: Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	150.0	187.8	37.8
2	Үл хөдлөх хөрөнгийн татвар	7.0	5.7	-1.3
3	Газрын төлбөр	7.7	10.6	2.9

4	Авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар	13.4	11.4	2.0
5	Зам ашигласны төлбөр	3.4	3.4	-
	Нийт дүн	196.5	220.8	24.3

Эх сурвалж: Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга

Аймгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлсэн байна.

Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын талаар: Тайлант онд улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 28.2 сая төгрөгөөр төлөвлөж 17.8 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж, 10.4 сая төгрөгөөр буюу 37.0 хувиар тасалсан байна.

Хүснэгт №13: Улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	6.5	4.5	-2.0
2	Дотоод бараа үйлчилгээний НӨАТ	20.2	11.3	-8.9
3	Ус бохирдуулсны төлбөр	-	0.35	0.35
4	Агаарын бохирдлын төлбөр	1.5	1.7	0.2
	Нийт дүн	28.2	17.8	-10.4

Эх сурвалж: Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн гүйцэтгэлийн танилцуулга.

Орлого тасарсан шалтгаан нь Ковид-19 цар тахлын улмаас жуулчны баазууд хэвийн ажиллаагүйгээс ААН орлогын албан татвар 2.0 сая төгрөгөөр, Дотоод бараа үйлчилгээний НӨАТ-ийн орлого 8.9 сая төгрөгөөр нийт 10.9 сая төгрөгөөр тасарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1."хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Тусламж санхүүжилтийн орлогын талаар

Тайлант онд тусламж санхүүжилтийн орлогыг 2,985.7 сая төгрөгөөр төлөвлөж, улсын өсвөөс 2,260.0 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 612.9 сая төгрөг, нийгмийн даатгалын сангаас 40.9 сая төгрөг, нийт 2,913.9 сая төгрөгөөр гүйцэтгэлийг хангуулж 97.6 хувтай байна.

Төсвийн зарлагын талаар:

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 9 хөтөлбөрт зориулан 2,985.7 сая төгрөгийн төсвийг баталснаас 2,858.4 сая төгрөгийг урсгал зардалд, 127.3 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Гүйцэтгэлээр урсгал зардалд 2,790.3 сая төгрөгийг, хөрөнгийн зардалд 96.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,886.9 сая төгрөг буюу 96.7 хувьтай байгаа нь Сангийн яамнаас тэвчиж болох зардлыг санхүүжүүлээгүйтэй холбоотой байна. Төсвийн хэмнэлтийг харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 14.9 сая төгрөг
- Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 6.6 сая төгрөг
- Байр ашиглалттай холбоотой зардал 3.1 сая төгрөг
- Норматив зардал 25.5 сая төгрөг
- Эд хогшил, урсгал засварын зардал 6.2 сая төгрөг
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж 3.1 сая төгрөг
- Бараа үйлчилгээний бусад зардал 5.2 сая төгрөг
- Урсгал шилжүүлгийн зардал 2.2 сая төгрөгөөр
- Хөрөнгийн зөрдөл 30.7 сая төгрөгөөр тус тус хэмнэгдсэн байна.

ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх 5 төсөл арга хэмжээнд 62.3 сая төгрөг батлагдсанаас 3 төсөл арга хэмжээнд 35.2 сая төгрөгийг зарцуулж хэрэгжээгүй 2 төсөл арга хэмжээний 27.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Сумын Засаг даргын хөтөлбөрийн хэрэгжилт 2,886.9 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 96.7 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

ТТЗ-ийн харьяа байгууллагууд нь хандив тусламжаар 7.9 сая төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 49.4 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд олсон орлогоос 9.1 сая төгрөг Эрүүл мэндийн даатгалын сангаас 128.3 сая төгрөг, Засаг даргын нөөц хөрөнгөөс 7.4 сая төгрөг нийт 146.1 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр бараа ажил үйлчилгээний зардалд 163.7 сая төгрөг, урсгал шилжүүлгийн зардалд 31.0 сая төгрөг нийт 194.7 сая төгрөгийг зарцуулж 1.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал. Үүнд: Корона вируст халдвар COVID-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах, орон нутагт малын гоц халдварт өвчинтэй тэмцэх гэх мэт үйл ажиллагаа нь онцлог асуудал байна.

Хатгал тосгоны төсвийн төвлөрүүлэн захирагч нь тайлант онд 208.5 сая төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 316.9 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 108.4 сая төгрөгөөр буюу 52.0 хувиар давуулан биелүүлсэн байна.

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Улс, орон нутгийн орлогын төлөвлөгөөг нэр төрлөөр нь авч үзвэл: Орон нутгийн орлогын төлөвлөгөөг 12.5 сая төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 10.9 сая төгрөгөөр тус тус тасалсан байна.

ТТЗ-ийн харьяа Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл болох 1.5 сая төгрөгийг татан төвлөрүүлээгүй 2021.12.31-ны өдрийн байдлаар 1.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7."Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд нь ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Шилэн дансны нэгсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг шалгалаа.



Шилэн дансны нэгдсэн цахим мэдээллийн системд мэдээлбэл зохих мэдээллүүдийг бүрэн мэдээлж ажилласан байна. Аудитаар алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалт, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид өгсөн төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад ирүүлж 100 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад асуудал илрээгүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 27.4 сая төгрөгийн алдаа зөрчил илрүүлснээс нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 2.5 сая төгрөгийн 2 алдааг аудитын явцад залруулж 24.9 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж, харьяа байгууллагуудын зөвлөмжийг хяналтдаа авч хэрэгжилтийг хангуулж ажиллах 1 зөвлөмж нийт 3 зөвлөмжийг өгсөн.

Залруулсан алдаа

Аудитын явцад нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 2.5 сая төгрөгийн залруулгыг хийсэн. Үүнд:

Үнэ төлбөргүй хүлээн авсан 1.3 сая төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө дансанд бүртгэснийг залруулсан.

Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний болон үр дүнгийн тайлангийн цалингийн зардлын дүн 1.2 сая төгрөгөөр зөрүүтэй нэгтгэснийг тус тус аудитын хугацаанд залруулсан.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитын талаар:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 5 төсвийн байгууллага, 1 ОНӨААН, 1 тусгай сан, 1 орон нутгийн ерөнхий орлогын данс нийт 8 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагыг түүвэрт хамруулж, 4 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт гаргасан байна. Аудитад хамрагдаагүй байгууллага байхгүй болно.

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 4 дүгнэлт өгсөн байна.

ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 274.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 148.2 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж 126.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

4.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлого бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл үйл ажиллагааны орлого 11.0 сая төгрөгөөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 0.6 сая төгрөгөөр, газрын төлбөрийн орлого 0.9 сая төгрөгөөр нийт 12.5 сая төгрөгөөр, Улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 10.9 сая төгрөгөөр дутуу



төвлөрүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 "хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" дахь заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлж ажиллах.

2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

ТТЗ-ийн харьяа Эрүүл мэндийн төвийн нэмэлт санхүүжилтийн дансанд 2021.12.31-ны өдрийн байдлаар 1.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7."Энэ хуулийн 43 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд төсвийн жил дуусахад төсвийн захирагчийн төсөв зарцуулах эрх нь дуусгавар болох бөгөөд төсвийн захирагчийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд татан төвлөрүүлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь заалтыг хэрэгжүүлж дансны үлдэгдлийг төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлж байх.

3. ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд илэрсэн зөрчлийн талаар

3.1. Илрүүлэлт:

ТТЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 299.6 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 173.0 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж 126.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

3.2. Өгсөн зөвлөмж:

Өөрийн хяналтад байдаг байгууллагуудын санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжүүдийг хяналтдаа авч хэрэгжилтийг хангуулж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Хатгал тосгоны ТТЗ	5	27.4	2	2.5					3	24.9
Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэл											
2	Захирагчийн ажлын алба	5	271.8	3	145.2					2	126.6
3	Ерөнхий боловсролын сургууль	2								2	
4	Хүүхдийн цэцэрлэг	3	3.0	1	3.0			1		1	
Дүн		10	274.8	4	148.2			1		5	126.6
Нийт дүн		15	302.2	6	150.7			1		8	151.5

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АХЛАХ АУДИТОР

Г.ЭРДЭНЭЧИМЭГ ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

Б.ДАВААНЯМ ОГНОО: